



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл тооцох зөвлөмж батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.7 дахь заалт, Улсын Их Хурлын Байнгын хорооны 2018 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм”-ийн 5.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл тооцох зөвлөмжийг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Батжаргал/-т даалгасугай.

3. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 20 дугаар тогтоолын 3 дахь заалтын “аргачлалыг” гэснийг “зөвлөмжийг” гэж өөрчилсүгэй.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба /Г.Банзрагч/-нд үүрэг болгосугай.

ДАРГА



Х.БУЛГАНТУЯА

Тэтгэвэр авах дундаж хугацааны
илэрхийлэл тооцох зөвлөмж

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгох даатгуулагчийн тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг тооцоход энэхүү зөвлөмжийг баримтална.

Хоёр. Тэтгэвэр авах дундаж хугацааны
илэрхийллийг тооцоход ашиглах мэдээлэл

2.1. Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл тооцоход дараах мэдээллийг ашиглана. Үүнд:

2.1.1. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагч /төрсөн он, тэтгэвэр авсан он/-ийн мэдээлэл.

$$A = \begin{pmatrix} A_{11} & \cdots & A_{1m} \\ \vdots & \ddots & \vdots \\ A_{n1} & \cdots & A_{nm} \end{pmatrix}$$

Тайлбар:

n-нас /тухайн жилд эрэгтэй-55, эмэгтэй-50 наснаас дээш тэтгэвэр авагчид/

m-он /сүүлийн 10 жил/

2.1.2. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авч байгаад нас барсан тэтгэвэр авагч /төрсөн он, нас барсан он/-ийн мэдээлэл.

$$B = \begin{pmatrix} B_{11} & \cdots & B_{1m} \\ \vdots & \ddots & \vdots \\ B_{n1} & \cdots & B_{nm} \end{pmatrix}$$

Тайлбар:

n-нас /тухайн жилд эрэгтэй-55, эмэгтэй-50 наснаас дээших тэтгэвэр авагчид/

m-нас барсан он /сүүлийн 10 жил/

2.1.3. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагч, даатгуулагч /тоо, насны ангиллаар/-ийн мэдээлэл.

$$E = \begin{pmatrix} E_1 \\ \cdots \\ E_n \end{pmatrix}$$

Тайлбар:
n-нас /тухайн жилд эрэгтэй-55, эмэгтэй-50/

Гурав. Тэтгэвэр авах дундаж хугацааны
илэрхийлэл тооцоолох аргачлал



3.1. Эдгээр зөвлөмжийн 2.1-д дурдсан мэдээллийг ашиглан тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг дараах байдлаар тооцоолно. Үүнд:

3.1.1. Энэ зөвлөмжийн 2.2.1, 2.2.2-д дурдсан өгөгдлөөс тэтгэвэр авагчид тухайн онд хэдэн насандаа нас барж байгаа хувийг дараах байдлаар гаргана.

$$C = \begin{pmatrix} \frac{B_{11}}{A_{11}} & \dots & \frac{B_{1m}}{A_{1m}} \\ \vdots & \ddots & \vdots \\ \frac{B_{n1}}{A_{n1}} & \dots & \frac{B_{nm}}{A_{nm}} \end{pmatrix}$$

Тайлбар:

- Тэтгэвэр авагчийн нас тус бүрээр сүүлийн 10 жилийн нас баралтын тархалтын харьцааг харуулна.

3.1.2. Энэхүү зөвлөмжийн 3.1.1-д тооцсон үр дүнгээс сүүлийн 10 жилд тэтгэвэр авагч хэдэн насанд ямар харьцаатай нас барж байгааг дараах байдлаар тооцоолон гаргана.

$$D = \begin{pmatrix} \frac{C_{11} + \dots + C_{1m}}{m} \\ \dots \\ \frac{C_{n1} + \dots + C_{nm}}{m} \end{pmatrix}$$

Тайлбар:

- Сүүлийн 10 жилд нас тус бүр дээр арифметик дунджаар ямар харьцаатай нас барж байгааг харуулна.

3.1.3. Энэхүү зөвлөмжийн 3.1.2-д заасны дагуу тооцоолон гаргасан үр дүнгээс нас тус бүрт нас барах магадлалын хувийг дараах байдлаар тархаана.

$$H = \begin{pmatrix} \frac{D_{11}}{\sum_1^n D_{n1}} \\ \dots \\ \frac{D_{n1}}{\sum_1^n D_{n1}} \end{pmatrix} * 100\%$$

Тайлбар:

Нас тус бүр дээр цаашид хэдэн хувийн нас барах магадлалыг таамаглахад ашиглана.

3.1.4. Тухайн онд нас барах тэтгэвэр авагчийн тооны магадлалыг дараах байдлаар гаргана.

$$K_{1+l} = \left(\begin{pmatrix} E_{1+l} \\ \dots \\ E_{n+l} \end{pmatrix} - \sum_0^l K_l \right) * H$$

Тайлбар:

$$K_0 = 0$$

$$L - (0, \infty)$$

(∞ - энэ нь хэдэн жилийн таамаг гаргах гэж байгаагаас хамааран хязгаарыг тогтооно.)

3.1.5. Он тус бүрд нас барж байгаа иргэдийн дундаж наслалтын тооцооллыг дараах байдлаар гаргана.

$$G_{1+l} = \frac{\sum_0^n \text{Нас} * K_{1+l}}{\sum_0^n k_n}$$

Тайлбар:

Он тус бүр дээр нас барах тэтгэвэр авагчдын дундаж нас

Дөрөв. Тооцоолол хянах

4.1. Энэхүү зөвлөмжийг ашиглан тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл тооцоолсон үр дүнг Үндэсний статистикийн хороо хянана.

---oOo---

